

АГУУЛГА

Нэг. Өнөөгийн байдал.....	2
Хоёр. Орлого, зарлага, ашигт ажиллагааны талаар.....	3
Гурав. Активын чанар, зээлийн үйл ажиллагааны талаар.....	
3.1 Активын талаар.....	4
3.2 Активын багцын чанар.....	5
Дөрөв. Пассивын бүтэц, төлбөрийн чадварын талаар.....	
4.1 Нийт эх үүсвэрийн талаар.....	5
Тав. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн талаар.....	6
Зургаа. Дүгнэлт.....	7

Хавсралтууд

ХЗХ-уудын нэгдсэн хураангуй тэнцэл

Актив, Пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан

Актив хөрөнгийн хамгааллалтын тайлан

Үр ашигтай санхүүгийн бүтцийн тайлан

Активын чанарын үзүүлэлтийн тайлан

Өгөөж, зардлын хувь хэмжээний тайлан

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан

Зохистой харьцааны үзүүлэлтүүдийн хураангуй тайлан

ХЗХ-дуудын нэгдсэн дэлгэрэнгүй тэнцэл */нийт ХЗХ-дуудаар/*

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ХОРШООДЫН 2008 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН**

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА


2008.11.07

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны тогтоолоор 11 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, харин □Бид хамтдаа□, □Фүжи партнерс□, □Гандирмаа□, □Тулга инвест□, □Дэлгэр орхон□ зэрэг 5 ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 204 ХЗХ-ны 2008 оны III улирлын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдахаар байсан.


Эдгээрээс 29 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 14.2 хувь нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй тул 23 ХЗХ-ны тайланг өмнөх улирлаар нь нэгтгэлд хамруулж, 175 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 85.8 хувь нь зохих журмын дагуу санхүүгийн болон зохистой харьцааны тайланг ирүүлснээр нийт 198 ХЗХ буюу ХЗХ-дын 97.1 хувь нь санхүүгийн тайлан нэгтгэгдлээ.



Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын тоо өмнөх оны мөн үеэс 1.6 дахин нэмэгдсэн байна.

Орон нутагт 101 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ХЗХ-дын 49.5 хувийг, тэдгээрийн нийт актив 6,932.199.88 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 16.1 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 5,965,824.44 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын олгосон зээлийн 17.2 хувийг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 3,757,280.26 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн 12.9 хувийг, нийт хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1,613,869.54 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын 20.5 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-г байршлын хувьд авч үзвэл Орхон аймагт 16, Завхан аймагт 10, Архангай аймагт 9, Өвөрхангай аймагт 8, Дархан уул, Увс аймагт тус бүр 6, Баян-Өлгий, Хэнтий, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймагт тус бүр 5, Хөвсгөл, Баянхонгор аймагт тус бүр 4, Төв аймагт 3, Дорнод, Булган, Сүхбаатар аймагт тус бүр 2, Говьсүмбэр, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.



Тайлант улиралд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 24,021 болж өссөн, харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-д 11,085 гишүүнтэй байгаа нь нийт гишүүдийн 46.1 хувийг эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд ХЗХ-дын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 2.8-5.0 хувь, хадгаламжийн хүүгийн түвшин дундажаар 1.5-2.5 хувь байна.

ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант улиралд ХЗХ-дын нийт орлого 9,253,022.3 мянган төгрөг ба нийт орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Нийт дүн	Хувь
Хүүгийн орлого			
1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	7,293,350.2	78.8%
2	Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	97,381.0	1.1%
3	Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	835,159.9	9.0%
4	Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	4,284.0	0.0%
5	Бусад хүүгийн орлого	10,642.7	0.1%
Үйл ажиллагааны бусад орлого			
6	Элсэлтийн хураамж	14,116.2	0.2%
7	Гишүүний татвар	13,638.5	0.1%
8	Үйлчилгээний хураамж	95,697.6	1.0%
9	Үйл ажиллагааны бусад орлого	216,228.9	2.3%
Үйл ажиллагааны бус орлого			
10	Торгуулийн орлого	39,675.0	0.02 %
11	Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	12,362.3	0.1%
12	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	127,237.9	1.4%
13	ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	288,532.2	3.1%
14	Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	157,051.3	1.7%
15	Бусад орлого	65,851.9	0.7 %
16	Онцгой шинжтэй орлого	13,667.2	0.1 %
17	Ердийн бус орлого	7,780.6	0.1%
Нийт орлого		9,253,022.3	100%

Нийт орлогын 76.4 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь зээлийн үйл ажиллагааны орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болж байгааг илтгэж байна.

Нийт зардал 7,856,717.9 мянган төгрөгт хүрсэн ба нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		Нийт дүн	Хувь
Хүүгийн зардал			
1	Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	3,351,168.0	42.7%
2	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал /1 жил хүртэлх хугацаатай/	1,245,460.8	15.9%
3	Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал /1 ээс дээш жилийн хугацаатай/	61,969.5	0.8%
4	Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	347,274.4	4.4%
5	Бусад хүүгийн зардал	7,118.3	0.1%
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал		732,350.4	9.3%
Үйл ажиллагааны зардал			
6	Боловсон хүчний зардал	915,006.7	11.6%
7	Бусад төрлийн зардал	824,387.4	10.5%
Үйл ажиллагааны бус зардал		181,754.4	2.3%
Ердийн бус зардал		1,836.5	0.0%
Татварын зардал		188,391.3	2.4%
НИЙТ ЗАРДАЛ		7,856,717.9	100%

Нийт зардлын 63.7 хувь нь хадгаламжийн хүүгийн зардал, 22.1 хувь нь үйл ажиллагааны зардал буюу боловсон хүчний холбогдолтой зардал байна.

Тайлант хугацаанд ашигтай ажилласан 153 ХЗХ нийт 1,585,091.5 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байгаа нь нийт ХЗХ-ны 77.3 хувийг эзэлж байгаа ба ашигтай ажилласан ХЗХ-дын арифметик дундаж ашиг 10,360.1 мянган төгрөг байна.

Харин 45 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 22.7 хувь нь 188,787.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ба зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, үйл ажиллагааны зардал өндөр, зээлийн чанар муу, зээлийн чанар муудсанаар эрсдлийн зардал өндөр байгаа үйл ажиллагаа жигдрээгүй зэргээс шалтгаалжээ.

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын талаар

ХЗХ-дуудын тайлант улирлын нийт активын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

ХӨРӨНГӨ	2008-III	Хувь
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	41,687,046,519.83	97.0%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,071,463,943.43	14.1%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,661,390,683.13	3.9%
2.Банкинд байршуулсан харилцах	1,578,669,194.84	3.7%
3.Банкинд байршуулсан хадгаламж	2,806,367,865.46	6.5%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	25,000,000.00	0.1%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	36,200.00	0.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	33,100,879,461.27	77.0%
6. Нийт зээл	34,783,502,766.61	80.9%
6.1.Хэвийн зээл	31,732,060,813.70	73.8%
6.2.Хугацаа хэтэрсэн зээл	1,054,255,973.22	2.5%
6.3.Чанаргүй зээл	1,997,185,979.69	4.6%
Хэвийн бус	567,758,151.30	1.3%
Эргэлзээтэй зээл	548,187,773.23	1.3%
Муу зээл	881,240,055.16	2.1%
6.4(Зээлийн эрсдэлийн сан)	1,682,623,305.34	3.9%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,003,091,914.58	4.7%
7. Байгууллага, хүмүүсээс авах авлага	418,726,150.22	1.0%
7. (Байгууллага, хүмүүсээс авах авлага эрсдлийн сан)	31,653,191.37	0.1%
8. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,616,018,955.73	3.8%

БУСАД ХӨРӨНГӨ	221,190,038.87	0.5%
9. Материал үнэ бүхий зүйл	93,686,719.64	0.2%
10. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	69,627,903.05	0.2%
11. Бусад актив	57,875,416.18	0.1%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	290,421,161.68	0.7%
12. Өмчлөх бусад хөрөнгө	333,093,414.56	0.8%
<i>13. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)</i>	<i>42,672,252.88</i>	<i>0.1%</i>
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,295,059,738.81	3.0%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,206,252,433.19	2.8%
14. Үндсэн хөрөнгө	1,662,512,311.54	3.9%
<i>15. (Үндсэн хөрөнгийн элэгдэл)</i>	<i>456,259,878.35</i>	<i>1.1%</i>
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	88,807,305.62	0.2%
16. Биет бус хөрөнгө	26,699,429.82	0.1%
17. Бусад	62,107,875.80	0.1%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	42,982,106,258.64	100.0%

Мөнгөн хөрөнгө нийт активын **14.1** хувь буюу **6,071,463.94** мянган төгрөг, цэвэр зээл нийт активын **77.0** хувь буюу **33,100,879.46** мянган төгрөг, авлага **4.7** хувь буюу **2,003,091.91** мянган төгрөг, бусад хөрөнгө **0.5** хувь буюу **221,190.04** мянган төгрөг, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө /цэврээр/ **0.7** хувь буюу **290,421.16** мянган төгрөг, үндсэн хөрөнгө /цэврээр/ **2.8** хувь буюу **1,206,252.43** мянган төгрөг, бусад эргэлтийн бус хөрөнгө **0.2** хувь буюу **88,807.31** мянган төгрөг байна.

Харин хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 37,589,906.8 мянган төгрөг болж нийт активт эзлэх хувийн жин нь 87.4 хувь байна.

3.2 Активын багцын чанар

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн бүтэц дараах байдалтай байна.

АКТИВ	/Мянган төгрөгөөр/	
	2008-III	Хувь
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	33,100,879.46	
Нийт зээл	37,783,502.76	100.0 %
1. Хэвийн зээл	31,732,060.81	83.9%
2. Хугацаа хэтэрсэн зээл	1,054,255.97	2.79%
3. Чанаргүй зээл	1,997,185.97	5.28%
<i>Хэвийн бус</i>	<i>567,758.15</i>	<i>1.5%</i>
<i>Эргэлзээтэй зээл</i>	<i>548,187.77</i>	<i>1.4%</i>
<i>Муу зээл</i>	<i>881,240.05</i>	<i>2.3%</i>
(Зээлийн эрсдлийн сан)	(1,682,623.31)	

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

4.1 Нийт эх үүсвэрийн талаар

ХЗХ-дуудын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц дараах байдалтай байна.

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2008-III	Хувь
1. ӨР ТӨЛБӨР	32,495,886,039.03	75.6%
ХАДГАЛАМЖ	29,020,238,535.80	67.5%
1. Хугацаагүй	2,260,730,115.08	5.3%
2. Хугацаатай	26,759,508,420.72	62.3%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,037,253,152.24	2.4%

3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,035,364,841.24	2.4%
4.Богино хугацаат төслийн санхүүжилт	1,888,311.00	0.0%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,163,089,584.13	5.0%
5. Татварын төлөх өглөг	39,758,532.61	0.1%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,757,784,941.84	4.1%
7. Өглөг	141,847,063.38	0.3%
8. Бусад пассив	223,699,046.30	0.5%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	275,304,766.87	0.6%
9. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	275,034,386.87	0.6%
10.Урт хугацаат төслийн санхүүжилт	270,380.00	0.0%
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	10,486,220,219.61	24.4%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,857,109,527.04	18.3%
11.Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,857,109,527.04	18.3%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	2,629,110,692.57	6.1%
12.Нөөцийн сан	684,507,031.63	1.6%
13.Дахин үнэлгээний сан	58,258,361.90	0.1%
14.Нийгмийн хөгжлийн сан	130,554,876.90	0.3%
15.Бусад сангууд	101,418,024.61	0.2%
16.Хандив, тусламж	32,525,318.00	0.1%
17.Бусад өмч	(6,826,296.98)	0.0%
18.Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,396,304,410.75	3.2%
19.Хуримтлагдсан ашиг/алдагдал	232,368,965.77	0.5%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	42,982,106,258.65	100.0%

Тайлант хугацааны эцэст хугацаатай болон хугацаагүй хадгаламж нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн 67.5 хувийг /29,020,238.53 мянган төгрөг/, хувь нийлүүлсэн хөрөнгө нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн 18.3 хувийг /7,857,109.53 мянган төгрөг/ тус тус эзэлж байна.

Богино хугацаат зээл, урт хугацаат өр төлбөр нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн 3 хувь байгаа бөгөөд энэ нь зөвхөн зээл авсан 45 ХЗХ буюу нийт ХЗХ-дын 22.7 хувьд нь хамаатай байна.

ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
А	АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН		
1	АКТИВЫН ЭРСДЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	1,572,196.94	1,682,623.31
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	5.7% <i>ХАНГААГҮЙ</i>
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
3	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	77.0%
4	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	0.7%
5	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.8%
6	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	67.5%
7	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	3.0%
8	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	18.3%
9	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	6.1% <i>ХАНГААГҮЙ</i>
10	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	394,366,603.9	684,507,031.6

В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	4.0%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
12	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	2.3% <i>ХАНГААГҮЙ</i>
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
13	АКТИВЫН ӨГӨӨЖ		4.2%
14	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		20.9%
15	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		28.4%

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ХЗХ-дын нийт актив 2008 оны III улирлын байдлаар 42,982.1 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын */банкны салбарын нийт актив 3,840,609.5 сая төгрөг/* 1.1 хувь, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 34,783.5 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт олгосон зээлийн */3,922,166.4 сая төгрөг/* 0.8 хувь, нийт хадгаламжийн үлдэгдэл 29,020.2 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт хадгаламжийн үлдэгдлийн */1,701,879.9 сая төгрөг/* 1.7 хувьтай тус тус тэнцэж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР